

## НУТГИЙН РАДИОГИЙН ДҮРЭМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэ дүрмээр ..... /оноосон нэр/ Нутгийн радиогийн үйл ажиллагааны зохион байгуулалт, түүнтэй холбогдсон бусад харилцааг зохицуулна. Энэ дүрэмд тусгагдаагүй бусад асуудлыг Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, эрх зүйн нийтлэг зарчмыг удирдлага болгон зохицуулна.
- 1.2. .... /оноосон нэр/ Нутгийн радио нь иргэдийн оролцоотойгоор олон нийтийн төлөө ажиллах, ашгийн төлөө бус, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага мөн.
- 1.3. .... /оноосон нэр/ Нутгийн радио нь өөрийн тэмдэг, бэлгэдэл /лого, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данс, ажлын байртай байна.
- 1.4. Нутгийн радиогийн Удирдах зөвлөлийн анхны хурлаар энэ дүрмийг баталсанаар Нутгийн радио үүсэн байгуулагдаж улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон нутаг дахь салбарт бүртгүүлсэнээр Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүснэ.
- 1.5. Нутгийн радио нь улс төр, бизнесийн ашиг сонирхлын зөрчил, нийгмийн аль нэг бүлэг, хэсгийн ашиг сонирхлоос хараат бусаар үйл ажиллагаагаа явуулж, гагцхүү нутгийн иргэдийн эрх ашигт үйлчилнэ

### ХОЁР. НУТГИЙН РАДИОГИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЗАРЧИМ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

2.1. .... Нутгийн радиогийн зорилго нь тухайн орон нутгийн хэмжээнд радио өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхэлж, сонсогчдын хэрэгцээ, сонирхолд нийцсэн төрөл бүрийн мэдээ, мэдээллийг иргэдийн оролцоотойгоор бэлтгэн хүргэхэд оршино.

#### 2.2. .... Нутгийн радио нь зорилгодоо хүрэхийн тулд дараахь зорилтыг биелүүлнэ

- 2.2.1. Нутгийн иргэдэд аливаа ялгаварлан гадуурхалтгүйгээр радиогийн үйл ажиллагаанд оролцох боломж олгох, нутгийн иргэдийг радиод ажиллах туршлага, дадлагатай болоход байнга туслах
- 2.2.2 Хөтөлбөр, нэвтрүүлгээ бэлтгэхдээ иргэдийн оролцоог дээд зэргээр хангах
- 2.2.3 Хөтөлбөрөө төлөвлөхдөө тухайн орон нутгийн иргэдийн санаа бодолд тулгуурлах
- 2.2.4 Орон нутгийн иргэдэд түгээх мэдээлэл нь нягт нямбай, тэнцвэртэй, үнэн бодит байх
- 2.2.5 Тухайн нутгийн иргэдийн дуу хоолой байж, тэдэнд үзэл бодол, санаа бодлоо илэрхийлэх боломж олгох
- 2.2.6 Тухайн иргэдийн итгэлтэй, найдвартай мэдээллийн эх сурвалж байх
- 2.2.7 Үйл ажиллагаандаа ёс зүйн дүрэм журмыг чандлан дээдлэх

2.2.8 Олон ургальч үзлийг эрхэмлэж, нутгийн иргэдийн өмнө тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахад олон талын санаа бодлыг тусгах иргэдийн индэр байх

### **2.3. Нутгийн радиод ажиллах иргэд нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:**

2.3.1. Ардчилсан нийгмийн үзэл санаа, соёл, зарчим, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх

2.3.2. Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, төрийн байгууллагаас мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандах

2.3.3. Хөтөлбөр нэвтрүүлгээ бэлтгэхдээ хэвлэлийн эрх чөлөөний зарчмуудад тулгуурлана

2.3.4. Алдаа мадаг гаргасан бол түүнийгээ залруулах, худал ташаа мэдээллийн төлөө хариуцлага хүлээх чадвартай байх

2.3.5. Үйл ажиллагаандаа иргэдэд үйлчлэх, иргэдийн өмнө хариуцлага хүлээх, иргэдэд тайлагнах, ил тод байх

2.3.6. Төрийн байгууллага, улс төрийн намуудад давуу эрх, боломж олгохгүй байх

### **ГУРАВ. НУТГИЙН РАДИОГИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

#### **3.1 Нутгийн радио нь дараах эрхтэй:**

3.1.1 Нутгийн радио нь өөрийн хөтөлбөр, нэвтрүүлгийн төлөө хариуцлага хүлээнэ. Харин өөрийн бэлтгэж, боловсруулаагүй нэвтрүүлгийн төлбөрт нэвтрүүлгийн агуулгын төлөө хариуцлага хүлээхгүй.

3.1.2 Сэтгүүл зүйн аргаар мэдээлэл олж авах, боловсруулах, түгээх

3.1.3 Төрийн болон бусад байгууллагаас мэдээлэл авах

3.1.4 Тухайн орон нутагт оршиж буй байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд нэвтрэн орж сурвалжлага бэлтгэх

3.1.5 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газрын хуралдаан, тухайн орон нутагт болж буй төрөл бүрийн арга хэмжээ, үйл явдлыг сурвалжлах

3.1.6 Мэдээллийн нууц эх сурвалжаа нууцлах

3.1.7 Төрийн, хувийн, төрийн бус зэрэг байгууллага, хувь хүнтэй хамтран ажиллах, холбогдох гэрээ байгуулах

3.1.8 Энэ дүрмийн зорилгоо хэрэгжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасны дагуу зар сурталчилгаа явуулах, бусад эх үүсвэрээс орлого олох

3.1.9 Монголын үндэсний олон нийтийн радиогоос зохих дэмжлэг авах

### **3.2 Нутгийн радио нь дараахь үүрэгтэй:**

- 3.2.1 Нутгийн иргэдийн эрх ашигт үйлчлэх нь эрхэм дээд эрмэлзэл мөн
- 3.2.2 Нутгийн олон нийтэд мэдээлэл түгээх, тэднийг соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх, зугаацуулах цэнгүүлэх
- 3.2.3 Хөтөлбөр, мэдээллийг техникийн болон мэргэжлийн зохих түвшинд бэлтгэх
- 3.2.4 Радиогийн ажилтан, ажилчин, тэдний хамтрагчдын хараат бус байдал, аюулгүй байдлыг хангах
- 3.2.5 Холбогдох өргөдөл, гомдлыг бүрэн дүүрэн, шуурхай шийдвэрлэх
- 3.2.6 Худал, ташаа мэдээлэл нэвтрүүлэхгүй байх
- 3.2.7 Хөтөлбөр бэлтгэхдээ эрүүл мэнд, хууль эрх зүй гэх мэт иргэний боловсролд зориулсан нэвтрүүлэг дийлэнх байлгахыг эрмэлзэнэ
- 3.2.8 Тухайн өдрийн нэвтрүүлгийн арваас доошгүй хувийг тухайн нутагт оршин сууж буй үндэстний, эсвэл угсаатны цөөнхийн хэл дээр бэлтгэж, түгээнэ
- 3.2.9 Нэвтрүүлгийн агуулгыг бэлтгэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, **конвенц болон** холбогдох шаардлагад бүрэн нийцүүлнэ
- 3.2.10 Садар самуун, хүчирхийлэл, дайнд уриалан дуудсан нэвтрүүлэг, хууль бус зар сурталчилгаа бүтээх, түгээхийг хориглоно.

### **ДӨРӨВ. НУТГИЙН РАДИОГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 4.1 Нутгийн радиогийн удирдах дээд байгууллага нь Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөлийг бүрдүүлэх, чөлөөлөх, бүрэн эрхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна
- 4.2 Нутгийн радио нь үйл ажиллагаанд нь хяналт тавих эрх, үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байх бөгөөд түүнийг бүрдүүлэх, чөлөөлөх, бүрэн эрхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна
- 4.3 Нутгийн радио нь түүний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах Радиогийн менежертэй байх бөгөөд **бүрдүүлэх, чөлөөлөх**, бүрэн эрхтэй холбоотой харилцааг энэ дүрмээр зохицуулна
- 4.4 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор байгуулах бөгөөд ИТХ-ын эрх, үүрэг гагцхүү үүгээр хязгаарлагдана
- 4.5 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг энэ дүрмээр түр хугацаанд байгуулагдсан Сонгон Шалгаруулах Хорооны саналыг баталж, томилно
- 4.6 Энэ дүрэмд зааснаар Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрх **томилогдсон дуусгавар** болж буй бол чөлөөлөх, томилох шийдвэр нь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор баталгаажина

## **ТАВ. СОНГОН ШАЛГАРУУЛАХ ХОРОО**

5.1 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүдийг Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас байгуулсан Сонгон Шалгаруулах Хороо ( цаашид Хороо гэх) сонгон шалгаруулна

5.2 Хороо нь таван гишүүнээс бүрдэх бөгөөд дундаасаа дарга, нарийн бичгийн даргаа сонгоно.

5.3 **Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан** байна. Хуралдааны дэг, журмыг Хорооны гишүүд хурлын эхэнд батална

5.4 Хорооны гишүүн нь энэ дүрмийн 5.7, мөн 6.2-т заасан Удирдах зөвлөлд тавигдах шаардлагыг мөн адил хангасан байна.

5.5 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд ажиллахаар өргөдлөө өгсөн иргэдийг Хороонд ажиллуулахыг хориглоно

5.6 Хороог томилохдоо Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас доорхи бүлэг хэсгийн төлөөллийг заавал харгалзана

- Малчин
- Эмэгтэйчүүд
- Угсаатны/үндэстний цөөнх
- Бизнес эрхлэгч/хоршоо
- Ахмад
- Залуучууд
- Орон нутгийн засаг захиргаа
- Шашин, сүм хийд
- Тариаланч/ногоочин
- Боловсролын байгууллага
- Төрийн бус, олон нийтийн байгууллага
- Тухайн орон нутгийн онцлогоос үүдсэн бусад бүлэг хэсэг

**5.7 Хороо дээрх төлөөллийг бүрдүүлэхдээ дор дурдсан зарчмыг зайлшгүй баримтална**

5.7.1 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд нэг намын төлөөлөл давамгайлахгүй байх

5.7.2 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд эцэг, эх, ах дүү, төрөл садны төлөөлөл давамгайлахгүй байх

5.7.3 Багуудын төлөөллийг тэнцвэртэй байлгах

5.8 Хороо Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг сонгон шалгаруулахдаа өргөдөл гаргагч нь урьд өмнө ямар нэг сонгуульт ажил эрхэлж байсан туршлагатай, эсвэл удирдах, зохион байгуулах ажлын дадлага туршлагатай бол давуу тал гэж үзэж болно

5.9 Хороо нь нутгийн иргэдийн нэрийн өмнөөс Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүнээр ажиллахаар хүсэл зорилгоо илэрхийлж, иргэдээс өргөдөл, дагалдах материалыг нягтлан үзэж, энэ дүрмийн 6.2-т заасан шалгуур, 5.7-д заасан бүлэг хэсгийн төлөөллийг хангасан эсэхийг харгалзан шалгаруулна

- 5.10 Ийнхүү шалгаруулахдаа нэрээ дэвшүүлсэн иргэдийг хамгийн олон санал авснаар нь дараалуулан жагсаалт үйлдэж, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүнээр томилуулахаар хүсэлтээ Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлан санал явуулна
- 5.11 Дээр дурдсан жагсаалтыг үйлдэхдээ Хорооны гишүүд саналаа нууцаар хурааж, түүнд бичигдсэн хүн нэг бүрийн авсан оноог тодорхой бичсэн байна.
- 5.12 Хороо энэ дүрэмд **заасан, хэлэлцэн** ажлын гурав хоногт багтаан хүсэлтээ Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжилна
- 5.13 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал Хорооны шийдвэрийг хүлээн авсанаас хойш долоо хоногоос хэтрүүлэлгүйгээр Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг томилон, нийтэд мэдээлнэ.
- 5.14 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал Хорооноос ирүүлсэн материалыг хүлээн авсаны дараа зөвхөн энэ дүрмийн 5.6-д заасан төлөөлөл, 5.7-д заасан зарчим хангагдсан эсэхийг хянан үзэж, хангагдаагүй тохиолдолд дахин хянуулахаар Хороонд буцааж болно. Ингэхдээ энэ дүрмийн 5.12-т заасан хугацааг зөрчихгүй
- 5.15 Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэр гарч, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл байгуулагдсанаар Хорооны бүрэн эрх нь дуусгавар болно
- 5.16 Хороог байгуулах бүрт бүрэлдэхүүн нь өмнөхөөс өөр байна

## **ЗУРГАА. УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

6.1 Удирдах зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд нутгийн радиогийн хараат бус байдал, тогтвортой үйл ажиллагааг хангах үндсэн үүрэгтэй

### **6.2 Удирдах зөвлөлийн гишүүн дор дурдсан шалгуурт нийцсэн байна**

- 6.2.1 Тухайн нутагт оршин суудаг
- 6.2.2 Өөрийн төлөөлөх бүлэг, хэсгийн эрхэлж буй ажил үүргийг гурваас доошгүй жил гүйцэтгэсэн байх
- 6.2.3 Өөрийн төлөөлөх бүлэг, хэсгийн дунд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн байх
- 6.2.4 Өөрийн төлөөлөх бүлэг, хэсгийн эрх ашиг, асуудал, бэрхшээлийн талаар сайн ойлголттой байх
- 6.2.5 Аливаа асуудалд шударга, голч байр сууринаас, туйлширахгүй хандах чадвартай байх
- 6.2.6 Тухайн бүлэг хэсгийн ашиг сонирхлыг төлөөлөх хүсэл эрмэлзэлтэй байх
- 6.2.7 Ажилд хариуцлагатай, нягт нямбай хандах чадвартай байх
- 6.2.8 Радиогийн үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох боломжтой байх
- 6.2.9 Ардчилал, нийгэм, түүний бүлэг хэсгүүдийн тухай ерөнхий ойлголттой байх
- 6.2.10 Ашиг сонирхлын зөрчилгүй буюу радиог ашиглан бизнесээ хөгжүүлэх, эсвэл улс төрийн, намын дуу хоолой болгох хүсэл эрмэлзэлгүй байх.

### **6.3 Удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах**

6.3.1 Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орж ажиллахыг хүсэж, өөрийгөө энэ дүрмийн 6.7-д заасан шалгуурт нийцэж буй гэж үзсэн иргэн бүхэн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй

- 6.4 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн тасралтгүй үйл ажиллагааг хангахын тулд Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө сонгон шалгаруулалтыг зарлана
- 6.5 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаас иргэдэд хүртээмжтэй аргаар түгээсэн байна
- 6.6 Сонгон шалгаруулах тухай мэдээлэлд сонгон шалгаруулалтын эхлэх, дуусах хугацаа, гишүүнд тавигдах шалгуур, өргөдлийн маягт, өргөдлийг хүлээлгэн өгөх цаг, хүлээн авах хүний нэр, хаяг, утас зэрэг мэдээллийг зайлшгүй багтаасан байна
- 6.7 Сонгон шалгаруулалтыг Сонгон шалгаруулалтыг зарласнаас хойш 20 хоногийн дотор Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга иргэдийн өргөдөл, дагалдах материалыг хүлээн авна. Хугацаандаа материалаа өгсөн иргэдийн материал дутуу бол бүрэн болгох боломжийг иргэнд нэг удаа олгоно
- 6.8 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа дууссан тохиолдолд зөвлөлүүд сонгуульт хугацааны тайлангаа Сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнаснаас хойш энэ дүрэмд заасан сонгон шалгаруулалтыг ажлын 7 хоногийн дотор багтаан эхлүүлнэ.
- 6.9 Хяналтын зөвлөлийн дүгнэлт гарч, Удирдах зөвлөлийн гишүүн хугацаанаас өмнө чөлөөлөгдвөл орны гишүүнийг энэ дүрэмд заасны дагуу сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр томилно
- 6.10 Удирдах зөвлөлийн бүрэн эрх**
- 6.10.1** УЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 6.10.2** Бүрэн эрхийн хугацаа нь дуусч, Удирдах зөвлөлийг шинэчлэн байгуулахдаа гишүүдийн гуравны хоёр нь солигдоно. Үлдэх гишүүдийг эхний удаад шодож сонгох ба үүнээс хойш шодохыг хориглоно
- 6.11 Удирдах зөвлөлийн гишүүд нь төлөөлж буй бүлэг, ажиллаж буй байгууллага, нэгжийнхээ дэмжлэгийг авч, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- 6.11.1 Нутгийн радиогийн дүрэмд өөрчлөлт оруулах, ингэхдээ Удирдах зөвлөлийн хоёр удаагийн дараалсан хурлаар гишүүдийн зуун хувийн саналаар шийдвэрлэнэ
- 6.11.2 Нутгийн радиог энэ дүрэмд заасан нөхцөлөөр үйл ажиллагааг нь зогсоох, татан буулгах, ингэхдээ энэ дүрэмд заасан нөхцөлийг үндэслэнэ
- 6.11.3 Нутгийн радиогийн менежерийг энэ дүрэмд заасан шалгуурын дагуу сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх
- 6.11.4 Нутгийн радиогийн санхүүгийн ажилтан, эсвэл нягтланг томилох
- 6.11.5 Нутгийн радиогийн стратеги, төсвийг батлах
- 6.11.6 Нутгийн радиогийн үйл ажиллагаанд холбогдох үндсэн шийдвэрүүдийг гаргах

- 6.11.7 Нутгийн радиогийн ажилтнууд, бусад оролцогчийн дагаж мөрдөх ёс зүйн дүрэм батлах
  - 6.11.8 Нутгийн радиод үүссэн асуудлыг Радиогийн менежерийн танилцуулсаны үндсэн дээр шийдвэрлэх
  - 6.11.9 Санхүүгийн үйл ажиллагааг санаачлах, түүний төслийг боловсруулах, хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцох
  - 6.11.10 Өөрийн боломж, нөхцөлд тохируулан өдрийн нэвтрүүлгийн нийт цагийг тогтоох
  - 6.11.11 Нутгийн радиогийн хөтөлбөрийн бодлого, нэвтрүүлгийн сүлжээг төслийг батлах
  - 6.11.12 Нутгийн радиогийн үйл ажиллагаа, хөтөлбөр, төсөлд хяналт тавих
  - 6.11.13 Иргэдийн гомдол маргааныг хэлэлцэж, шийдвэр гаргах
  - 6.11.14 Нутгийн радиогийн ажилтан, албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах
  - 6.11.15 Мэдээллийн төлбөрийн хувь хэмжээ, санхүүжилтын гэрээ, төрийн болон төрийн бус байгууллага, бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй хийх гэрээ зэргийг хянаж, баталгаажуулах
  - 6.11.16 Нутгийн радиогийн үйл ажиллагаанд холбогдох бусад шийдвэр гаргах
- 6.12 Удирдах зөвлөлийн даргыг томилох, чөлөөлөх**
- 6.12.1 Удирдах зөвлөл нь анхныхаа хурлаар Дарга, дэд даргаа гишүүд дундаасаа сонгоно
  - 6.12.2 Удирдах зөвлөлийн аль ч гишүүн өөрийгөө Даргад нэр дэвшүүлэх эрхтэй
  - 6.12.3 Удирдах зөвлөлийн даргын бүрэн эрхийн хугацаа нь гурван жил бөгөөд нэг удаа улиран сонгогдох эрхтэй
  - 6.12.4 Даргыг сонгохдоо өрсөлдөгч нь хоёроос дээш байгаа тохиолдолд тухайн нэр дэвшигч өөрийгөө оруулан нийт гурван хүний төлөө саналаа өгч болохоор нэр дэвшигчдийн жагсаалт гаргана.
  - 6.12.5 Даргыг нууц санал хураалтаар гишүүдээс хамгийн олон санал авсан хүнийг сонгоно
  - 6.12.6 Удирдах зөвлөлийн даргын эзгүйд түүний бүрэн эрхийг Дэд дарга хэрэгжүүлэх бөгөөд түүнийг энэ дүрэмд заасан нууц санал хураалтаар хоёрдугаар байранд орсон гишүүнийг томилно
- 6.13 Удирдах зөвлөлийн даргын бүрэн эрх**
- 6.13.1 Удирдах зөвлөлийн дарга нь дор дурдсан бүрэн эрхтэй
    - 6.13.1.1 Гадаад, дотоодод Удирдах зөвлөл, радиог төлөөлнө
    - 6.13.1.2 Удирдах зөвлөлийн хурал даргалах
    - 6.13.1.3 Аливаа асуудлаар шийдвэр гаргахад гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд бие даан шийдвэр гаргах

6.13.1.4 Нутгийн радиогийн санхүүгийн баримт дээр нэгдүгээр гарын үсэг зурах

#### **6.14 Удирдах зөвлөлийн даргыг чөлөөлөх**

6.14.1 Удирдах зөвлөлийн даргыг дор дурдсан нөхцөлд чөлөөлнө

6.14.1.1 Сайн дураар чөлөөлөгдөхөөр өргөдөл гаргасан

6.14.1.2 Түүнийг чөлөөлөхөөр Хяналтын зөвлөлийн дүгнэлт гарсан

6.14.1.2 Энэ дүрэм, мөн радиогийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн нь илэрсэн

6.14.1.3 Авлига, гэмт хэрэгт холбогдсон нь шүүхээр нотлогдсон

#### **6.15 Удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эсэх асуудлыг Удирдах зөвлөл бие даан дараах үндэслэлээр шийдвэрлэнэ. Үүнд:**

6.15.1 Удирдах зөвлөлийн зөвшөөрөлгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийт хурлын талаас илүүд нь оролцоогүй;

6.15.2 Эрүүгийн хэрэгт холбогдож, түүндээ ял шийтгүүлсэн бол

6.15.3 Удирдах зөвлөлийн гишүүний үүргийг эрүүл мэндийн хувьд хэрэгжүүлэх чадваргүй болох нь илэрхий болсон,

6.15.4 Дүрэмд заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн

6.15.5 Тухайн гишүүнийг чөлөөлөхөөр Хяналтын зөвлөлийн дүгнэлт гарсан

6.16 Хугацаанаасаа өмнө чөлөөлөгдсөн гишүүний оронд шинэ гишүүнийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал Хорооны жагсаалтад бичигдсэн хүнийг оруулан энэ дүрэмд заасан хугацаанд томилж, шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

#### **6.17 Удирдах зөвлөлийн хурлын журам**

6.17.1 Удирдах зөвлөлийн анхны хурлыг Хороо, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас томилсон хоёр хүн энэ дүрэмд заасан журмын дагуу зохион байгуулна. Томилогдсон хоёр хүний нэг нь анхны хурлыг даргалж, нөгөө нь тэмдэглэл хөтөлнө

6.16.2 Удирдах зөвлөлийн анхны хурлаар дараахь асуудлыг хэлэлцэнэ

6.16.2.1 Нутгийн радиогийн дүрэм батлах

6.16.2.2 Удирдах зөвлөлийн дарга, дэд даргыг томилох

6.16.2.3 Нутгийн радиогийн ёс зүйн дүрэм батлах

6.16.2.4 Радиогийн менежер, нягтлан томилох

6.17.2 Анхны хуралдааны тэмдэглэл, тогтоолыг энэ дүрэмд заасан хугацаанд олон нийтэд мэдээлнэ

## **6.18 Удирдах зөвлөлийн хурал**

6.18.1 Удирдах зөвлөл нь хамтын удирдлагын зөвлөлдөн зохицуулах үйл ажиллагаагаа хурлын хэлбэрээр, энэ дэгийг баримтлан явуулна.

6.18.2 Удирдах зөвлөлийн хурлын ажиллагаа нь асуудлыг чөлөөтэй хэлэлцэх, цөөнхийн санал бодлыг хүндэтгэж, олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.

6.18.3 Удирдах зөвлөлийн хурал 7 хоногт нэг удаа хуралдах бөгөөд дараагийн хурлын болох газар, хугацааг үүгээр урьдчилан тогтооно.

6.18.4 Удирдах зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.

6.18.5 Хурлыг Удирдах зөвлөлийн дарга, түүний эзгүйд дэд дарга даргална.

6.18.6 Удирдах зөвлөлийн гишүүн хуралд оролцох боломжгүй бол энэ тухайгаа хурал эхлэхээс өмнө Дарга, эсхүл Радиогийн менежерт мэдэгдэнэ

6.18.7 Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх бодлого, стратеги зэрэг нухацтай асуудлын тухай танилцуулга, хуралдаанаас гарах шийдвэрийн төслийг гишүүдийн тоогоор хувилж, хурал болохоос доод тал нь гурав хоногийн дотор хүргэнэ. Ийм танилцуулга, шийдвэрлүүлэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төсөл нь товч тодорхой, ойлгомжтой, судалгаа, тооцоог бүрэн хийсэн байх шаардлагатай

6.18.10 Хурлын эхэнд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг батална

6.18.11 Тухайн хэлэлцэх асуудалд холбогдох албан тушаалтнуудыг хуралд байлцуулж болно.

6.18.12 Хуралдаанаас тогтоол гарч, гишүүд гарын үсэг зурсанаар шийдвэр хүчин төгөлдөр болно

6.18.13 Асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд Удирдах зөвлөлийн даргын саналаар шийдвэр гаргана

6.18.14 Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг хурлын эхэнд томилсон нарийн бичгийн дарга үйлдэж, бүх гишүүн гарын үсэг зурж, радиогийн тамга тэмдэг дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно

6.18.15 Удирдах зөвлөлийн хурлын тухай товч мэдээллийг гаргасан шийдвэрийн хамт ажлын гурав хоногт багтаан өөрийн радиогоор олон нийтэд мэдээлж, өөрийн байр, сумын Засаг даргын газрын зарлалын самбарт тавьсан байна. Цахим хуудастай бол түүнд энэ мэдээллийг заавал байрлуулна

6.18. 16 Хурлын тэмдэглэл нь бүрэн эхээрээ нийтэд ил тод байх бөгөөд хүссэн иргэн авч танилцаж болно.

6.18.17 Хурлын тэмдэглэлд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, урилгаар оролцсон хүмүүсийн нэр, албан тушаал, шийдвэрийн төсөл, тэдгээрийн танилцуулга, дүгнэлт, санал зэрэг хуралд ашигласан баримт бичгийг хавсаргана.

6.18.18 Хурлын тэмдэглэлд хурал эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцсэн он, сар, өдөр, цаг минут, ирц (тоо, хувиар), оролцоогүй гишүүний нэр, шалтгаан ямар асуудал, хаанаас хэн төлөөлж оруулсан тухай товч томъёолол, хэлэлцэж байгаа асуудалтай холбогдсон асуулт, хариулт, гаргасан санал, шүүмжлэл, хэлсэн үг, санал хураалтын дүн (тоо, хувиар), хэрэв нэрээр санал хураавал гишүүн бүрийн нэр, өгсөн санал, шаардлагатай бусад мэдээллийг заавал багтаасан байна

6.18.19 Удирдах зөвлөлийн хурал иргэдэд нээлттэй байна

6.18.20 Удирдах зөвлөлийн хуралд оролцохыг хүссэн иргэн саналын эрхгүйгээр ажиглагчаар оролцоно

6.18.21 Удирдах зөвлөлийн хурлаар хүний асуудал хэлэлцэж, шийдвэр гаргах бол өөрийг нь заавал байлцуулна. Боломжгүй тохиолдолд өөрийг нь эзгүйд асуудлыг хэлэлцэх зөвшөөрлийг бичгээр авсан байна

### **Долоо. Радиогийн менежер**

7.1 Радиогийн менежерийг сонгон шалгаруулах томилох, чөлөөлөх

7.2 Удирдах зөвлөл нутгийн радиогийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдуулахаар Радиогийн менежерийг сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно.

7.3 Радиогийн менежерийн сонгон шалгаруулалтыг энэ дүрэмд заасантай адил аргаар зарлаж, адил аргаар Удирдах зөвлөлийн гишүүдийн нууц санал хураалтаар томилно

7.4 Радиогийн менежерийн ажил үүргийн тодорхойлолт, өмч хөрөнгө захиран зарцуулах эрх, цалин урамшууллын хэмжээг Удирдах зөвлөлөөс тогтоож, Дарга түүнтэй гэрээ байгуулна

### **7.5 Радиогийн менежер нь дор дурдсан шалгуурыг хангасан байна. Үүнд:**

7.5.1 Дээд боловсролтой

7.5.2 Радиогийн үйл ажиллагааг удирдах, зохион байгуулах хүсэл эрмэлзэлтэй

7.5.3 Сурснаа бусдад заах, сургах чадвартай

7.5.4 Бусдад өөрийгөө ойлгуулах, бусдыг ойлгох чадвартай

7.5.5 Тайлан, бичгийн бусад материал боловсруулах чадвартай

7.5.6 Хэл, ярианы чадвар сайтай

7.5.7 Компьютерийн хэрэглээний программ ашиглаж чаддаг байх

7.5.8 Интернэтийн анхан шатны мэдлэгтэй байх

7.6 Дээр дурдсан шалгуурыг баримтлахдаа Удирдах зөвлөл тухайн нэр дэвшигч нь хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүй, санхүү, удирдлагын чиглэлийн туршлагатай байвал давуу тал гэж үзэж болно.

### **7.6 Радиогийн менежерийн эрх үүрэг**

7.6.1 Радиогийн менежер дор дурдсан эрх эдэлнэ

7.6.1.1 Нутгийн радиог төлөөлөх

7.6.1.2 Радиогийн ажилтнуудыг сонгон шалгаруулах

- 7.6.1.3 Удирдах зөвлөлөөс тогтоосон эрх мэдлийн хэмжээнд радиогийн өмч хөрөнгийг захиран зарцуулах
- 7.6.1.4 Боловсон хүчин, сайн дурын ажилтантай гэрээ хийх, цуцлах
- 7.6.1.5 Түншлэгч, сурталчлагч, дэмжигч, хандивлагчтай харилцах
- 7.6.1.6 Нутгийн радиогийн нэрийн өмнөөс төсөл, хөтөлбөр боловсруулах, Удирдах зөвлөлөөс тогтоосон эрх мэдлийн хүрээнд гэрээ хийх, төслийн хөрөнгийг захиран зарцуулах
- 7.6.1.7 Удирдах зөвлөлөөс олгосон эрх мэдлийн хүрээнд байгууллага, хувь хүнтэй гэрээ хийх
- 7.6.1.8 Нутгийн радиогийн санхүүгийн баримтад хоёрдугаар гарын үсэг зурах
- 7.6.1.9 Удирдах зөвлөлөөс олгосон бусад эрх
- 7.6.2 Радиогийн менежер дор дурдсан үүрэг хүлээнэ**
- 7.6.2.1 Нутгийн радиогийн төлөө Удирдах зөвлөлийн өмнө хариуцлага хүлээнэ
- 7.6.2.2 Нутгийн радиогийн стратеги, хөтөлбөрийн бодлого боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах
- 7.6.2.3 Улирал, хагас болон бүтэн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах
- 7.6.2.4 Удирдах зөвлөлийн шийдвэрийг биелүүлэх
- 7.6.2.5 Долоо хоног бүр Удирдах зөвлөлд өдөр тутмын ажлын тухай мэдээлэх
- 7.6.2.6 Улирал, хагас, бүтэн жилээр үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тавьж хэлэлцүүлэх
- 7.6.2.7 Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах
- 7.6.2.8 Өдөр тутмын ажилд хяналт тавих, үнэлгээ хийх
- 7.6.2.9 Нутгийн радиогийн үйл ажиллагаа дахь бэрхшээлийг тодорхойлж, задлан шинжлэх
- 7.6.2.10 Нутгийн радиогийн үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдалд анхааран, төсөл хөтөлбөр боловсруулах
- 7.6.2.11 Нутгийн радиогийн зорилго, зорилгод нийцүүлсэн хөтөлбөр, нэвтрүүлгийн сүлжээ боловсруулж, Удирдах зөвлөлөөр батлуулах
- 7.6.2.12 Нутгийн радиотой холбогдох аливаа хүсэлтийг хүлээн авах, шаардлагатай бол Удирдах зөвлөлд уламжилж, шийдвэр гаргуулах
- 7.6.2.13 Нутгийн радиотой холбоотой санал гомдлыг өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх, шаардлагатай бол Удирдах зөвлөлд уламжилж, шийдвэр гаргуулах

- 7.6.2.14 Нутгийн радиод ажиллуулах боловсон хүчин, сайн дурын ажилтан шалгаруулж авах, сургах, дадлагажуулах, радиод ажиллах хүсэлтэй иргэдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах
- 7.6.2.15 Төлөвлөгөөт болон Удирдах зөвлөлийн шаардлагатай гэж үзсэн тусгай тайлан бэлтгэх
- 7.6.2.16 Удирдах зөвлөлөөс ногдуулсан бусад үүрэг
- 7.7 Удирдах зөвлөл радиогийн менежер сонгон шалгаруулах, түүний үйл явц, томилсон шийдвэрийг дүрэмд тусгаснаар олон нийтэд ил тод мэдээлнэ
- 7.8 Нутгийн радиогийн тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор Удирдах зөвлөл, менежер дор дурдсан ажилтныг нэн тэргүүнд ажиллуулна
- 7.9 Нутгийн радиогийн санхүүгийн үйл ажиллагааг хариуцсан Санхүүгийн ажилтан, эсвэл нягтлан бодогчийг Удирдах зөвлөл, эсвэл Менежерийн санал болгосноор Удирдах зөвлөл томилно
- 7.10 Нутгийн радиогийн нэвтрүүлэг бэлтгэх, боловсруулах, түгээх цацах, мөн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээг хариуцсан Техникийн ажилтанг Менежер томилон ажиллуулна
- 7.11 Хөтлөгч, нэвтрүүлэгчийг Радиогийн менежер сонгон, томилж ажиллуулна.
- 7.12 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, ажилтнуудын цалин хөлс, урамшуулал
- 7.12.1 Нутгийн радиогийн санхүүгийн чадавхиас хамаарч Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийн гишүүн, ажилтнуудад цалин урамшуулал олгох эсэхийг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ
- 7.12.2 Удирдах зөвлөл цалин хөлсний асуудлаар шийдвэр гаргахдаа нэн түрүүнд Менежер, санхүүгийн ажилтан, техникч зэрэг тогтмол ажиллаж буй ажилтнуудад олгоно**
- 7.12.3 Дээр дурдсанаас бусад ажилтнуудын цалин хөлс, урамшууллыг дараах хүчин зүйлсээс хамаарч олгох шийдвэрийг Удирдах зөвлөл гаргана. Үүнд:
- 7.12.3.1 Мөнгөн хөрөнгийн бэлэн байдал
- 7.12.3.2 Радиогийн сайн дурын ажилтнуудын нэмэр хандив
- 7.12.4 Радиогийн үйл ажиллагаанд зориулсан хугацаа
- 7.12.5 Хувийн зайлшгүй хэрэгцээ, шаардлага
- 7.13 Албан үүргийнхээ дагуу Нутгийн радиод ажилласан сайн дурын ажилтанд олгох урамшуулал нь тэдний ажил хөдөлмөр эрхэлдэг үндсэн байгууллагаас олгох хэмжээнээс хэтрэхгүй.
- 7.14. Удирдах зөвлөл, Радиогийн менежер нь Хяналтын зөвлөлийн гишүүдэд нөхөн төлбөрөөс, өөрөөр хэлбэл хуралд ирж, очих унаа тээврийн хөлс, хуралд оролцсон урамшууллаас бусад зориулалтаар аливаа урамшуулал, хөлс олгохыг хориглоно

## Ёс. Хяналтын зөвлөл

9.1 Нутгийн радио нь Удирдах зөвлөл, Менежерийн үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, санхүүгийн зарцуулалтад байнгын хяналт тавьж, иргэдийн санал гомдлын дагуу хяналт шалгалт хийх эрх бүхий Хяналтын зөвлөлтэй байна

9.2 Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа Удирдах зөвлөл, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд тайлагнана.

9.3 Хяналтын зөвлөлийн гишүүдийг энэ дүрмийн ... заасан Удирдах зөвлөлийг сонгон шалгаруулах, томилох, чөлөөлөх журмын дагуу зохион байгуулна

9.4 Хяналтын зөвлөлийг Сонгон шалгаруулах Хорооны хүсэлтээр сумын ИТХ-ын Удирдах зөвлөл томилох тухайн өдрийн шийдвэрээр байгуулна

9.5 Хяналтын зөвлөл нь 3 гишүүнтэй байх бөгөөд тэдэнд энэ дүрмийн 6.7-д заасан шалгуур тавигдана. Харин удирдлага, эдийн засаг, санхүүгийн ажлын туршлага давуу тал байж болно

9.6 Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгон шалгаруулах, томилох үйл явцыг энэ дүрмийн дагуу Удирдах зөвлөлтэй адил шаардлага, зарчмаар, нэг цаг хугацаанд зохион байгуулах бөгөөд харин Хяналтын зөвлөлийг бүрэн бүрэлдэхүүнээр нь солино. Дүрэмд заасан ил тод байдлын зарчим мөн адил үйлчилнэ

9.7 Хяналтын зөвлөлийн гишүүнийг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө чөлөөлж болно.

9.7.1 Өөрийн саналаар

9.7.2 Хяналтын зөвлөлийн даргын зөвшөөрөлгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр Хяналтын зөвлөлийн нийт хуралдааны талаас илүүд нь оролцоогүй;

9.7.3 Эрүүгийн хэрэгт холбогдож, түүндээ ял шийтгүүлсэн,

9.7.4 Эрүүл мэндийн хувьд үүргээ биелүүлэх чадваргүй болох нь илэрхий болсон

9.7.5 Нутгийн раидогийн Ёс зүйн дүрмийг удаа дараа зөрчсөн

9.7.6 Хяналтын зөвлөлийн даалгаврыг гүйцэтгэх явцдаа зөрчил гаргасан

9.7.7 Энэ дүрэмд заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн

9.7.8 Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эсэх асуудлыг Хяналтын зөвлөл өөрийн хурлаар, гишүүдийн дийлэнх олны саналаар шийдвэрлэнэ. Ингэхдээ Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай энэ дүрэмд заасан зохицуулалт нэгэн адил үйлчилнэ

9.7.9 Хяналтын зөвлөл тухайн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх болсон тухай шийдвэрээ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мэдэгдэж, мэдээллийг энэ дүрэмд заасан аргаар олон нийтэд хүргэнэ

9.9 Хяналтын зөвлөл нь Нутгийн радиогийн санхүүгийн зарцуулалтыг хянах, шалгах, тайлагнахдаа холбогдох хууль тогтоомжийн хүрээнд мэргэжлийн магадлан шинжлэх, хөндлөнгийн хяналтын байгууллагын туслалцаа авч болно.

9.10 Хяналтын зөвлөлөөс гаргах албан ёсны аливаа шийдвэр, акт, зөвлөмж, дүгнэлт, мэдэгдэлд хяналтын зөвлөлийн гишүүд зуун хувь гарын үсэг зурснаар хүчин төгөлдөрт тооцогдоно.

9.11 Хяналтын зөвлөл шийдвэрээ олон нийтэд ил тод байлгаж, энэ **дүрмийн ..** заасан аргаар нийтэд хүргэнэ.

9.12 Хяналтын зөвлөл нь энэ дүрэмд нийцүүлэн түүний чиг үүргийг хэрэгжүүлэх, дотоод хяналтыг үр нөлөөтэй байлгахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор өөрийн дотоод журмыг баталж, мөрдөнө

9.13 Дотоод журамд дор дурдсан хяналтын зүйлийг зайлшгүй багтаасан байна.

9.13.1 Нутгийн радиогийн дүрмийн биелэлт, түүнтэй холбоотой санал гомдол

9.13.2 Нутгийн радиогийн ёс зүйн дүрмийн биелэлт, түүнтэй холбоотой санал гомдол

9.13.3 Удирдах зөвлөлийн шийдвэр, түүний хэрэгжилт

9.13.4 Нутгийн радиогийн эрхэм зорилт, зорилго, үнэт зүйлсийн биелэлт

9.13.5 Нутгийн радиогийн бодлого, стратегийн биелэлт

9.13.6 Нутгийн радиогийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө

9.13.7 Удирдах зөвлөлийн гишүүдийн чиг үүргийн биелэлт, тэдэнтэй холбоотой санал гомдлыг хүлээн авах, шалгах, шийдвэр гаргах

9.13.8 Санхүүгийн зарцуулалт, санхүүгийн асуудлаарх Удирдах зөвлөлийн шийдвэр

9.13.9 Радиогийн Менежерийн үйл ажиллагаа, санхүүгийн зарцуулалт

#### **9.14 Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрх**

9.14.1 Удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх тухай дүгнэлт гаргах

9.14.2 Удирдах зөвлөлийн хэлэлцэх асуудалд санал өгөх

9.14.3. Удирдах зөвлөлийн хуралд таслах эрхгүйгээр оролцох

9.14.4 Удирдах зөвлөлийн гишүүн, менежерээс хариуцсан чиглэлээр нь мэдээлэл авах

9.14.5 Удирдах зөвлөлөөс аливаа асуудлаар байгуулсан ажлын хэсэгт орж, ажиллах, даргалах

9.14.6 Удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тогтмол хүлээж авч, танилцах

9.14.7 Удирдах зөвлөлийн гишүүн, радиогийн ажилтны сонирхлын зөрчлийн талаар дүгнэлт гаргах

9.14.8 Аудитын байгууллагатай харилцах

9.14.9 Радиогийн ажилтнуудын хуралд оролцох

9.14.10 Радиогийн менежерээр эд хөрөнгийн тооллого хийлгэн батлах

9.14.11 Радиогийн ажилтан, иргэдийн радиогийн үйл ажиллагаатай холбоотой хүсэлт, санал гомдлыг хүлээн авах, шаардлагатай гэж үзвэл Удирдах зөвлөлд уламжлан шийдвэр гаргуулах

9.14.12 Радиотой холбоотой бусад үйл ажиллагаа

9.15 Энэ дүрмээр зохицуулаагүй харилцааг Хяналтын зөвлөл дотоод журмаараа зохицуулна

## **АРАВ. НУТГИЙН РАДИОГИЙН ӨМЧ, САНХҮҮЖИЛТ**

10.1. Удирдах зөвлөл нь Нутгийн радиогийн санхүүгийн удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлнэ.

10.2. Нутгийн радиогийн өмч, хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд.

10.2.1. Үүсгэн байгуулагч, үйлчлүүлэгч, иргэд, дэмжигч, олон улсын байгууллагын хандив

10.2.2. Сумын төсвийн дэмжлэг

10.2.3 Хөтөлбөр, төслийн орлого

10.2.4 Төлбөрт, захиалгат нэвтрүүлгийн орлого

10.2.5 Зар сурталчилгааны орлого,

10.2.6 Дүрмийн зорилгыг хэрэгжүүлэхтэй холбогдсон аж ахуйн үйл ажиллагаанаас олсон орлого,

10.2.7 Хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрийн хөрөнгө.

10.3 Энэ дүрмийн 16.2.5 зүйлд заасан төлбөрт, захиалгат нэвтрүүлгийн орлого олон нийтэд ил тод байх бөгөөд олон нийтийг төөрөгдүүлэхгүйн тулд захиалагчийн нэрийг нэвтрүүлэгт заавал онцлон дурдана

10.4 Санхүүгийн журмыг Удирдах зөвлөлийн хурлаар батална. Санхүүгийн журам нь Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, бүх ажилтнуудад албан ёсоор танилцуулагдсан байна.

10.5 Санхүүгийн баримтанд нэгдүгээр гарын үсгийг Удирдах зөвлөлийн дарга, хоёрдугаар гарын үсгийг Менежер зурах эрхийг Удирдах зөвлөлөөс шийдвэр гарган баталгаажуулна.

10.6 Нутгийн радиогийн орлого, өмчийг зориулалтын бусаар зарцуулах, бусдад шилжүүлэхийг хориглоно.

10.7 Зар сурталчилгааны орлого нь Зар сурталчилгааны тухай хууль, холбогдох хууль тогтоомжийн зүйл заалтыг зөрчиж болохгүй

## **АРВАН НЭГ. НУТГИЙН РАДИОГИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАХ**

11.1 Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу Нутгийн радиогийн үйл ажиллагаа, төсөв санхүү, боловсон хүчний нөөц, өөрийн хөрөнгөөр бараа, бүтээгдэхүүн худалдан авсан тухай мэдээлэл олон нийтэд ил тод байна

11.2 Нутгийн радио хагас жилийн болон жилийн тайлангаа сумын иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж хэлэлцүүлнэ.

11.3 Хагас жилийн болон жилийн тайланг сумын иргэдийн олонх оролцсон аливаа уулзалт, сумын номын сан, цахим хуудас, өөрийн радио зэрэг нийтэд хүртээмжтэй хэлбэрээр олны хүртээл болгоно

11.4 Тайланд дараахь мэдээллийг тусгана:

11.4.1 радиогийн хөтөлбөрийн бодлогын хэрэгжилт, нэвтрүүлгийн хөтөлбөрүүдийн тухай мэдээлэл;

11.4.2 санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлт;

11.4.3 радиогийн бусад байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээний хэрэгжилт;

11.4.4 Бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ авсан тухай, сонгон шалгаруулалт хийсэн тухай мэдээлэл

11.4.5 Боловсон хүчний тухай мэдээлэл

11.4.6 Сонсогчдын дунд хийсэн судалгааны товч тайлан

11.4.7 Стратеги, зорилт, хөтөлбөрт оруулах өөрчлөлтийн талаархи санал;

11.4.8 Сонсогчдын санал, хүсэлт, гомдлын талаархи мэдээлэл, тэдгээрийг шийдвэрлэсэн байдал

11.4.7 Ил тод байдлыг хэрхэн хангасан, иргэдийн мэдээлэл авах хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тухай мэдээлэл

11.5 Нутгийн радио үйл ажиллагаагаа ил тод байлгах, олон нийтийн санаа бодлыг тусгах зорилгоор сонсогчидтой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлнэ

11.6 Ил тод байдал, мэдээллийн нээлттэй байдалтай холбоотой, энэ дүрэмд заагаагүй харилцааг Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулиар зохицуулна

## **АРВАН ХОЁР. УЛСЫН ИХ ХУРАЛ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ҮЕИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

12.1. Нутгийн радио нь Улсын Их Хурал, Ерөнхийлөгч болон Орон нутгийн сонгууль /цаашид “сонгууль” гэх/-тай холбоотой Монгол Улсын холбогдох хуулийн зүйл заалтыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

12.2. Удирдах зөвлөл Нутгийн радиогийн Сонгуулийн үеэр баримтлах зарчмыг Монгол Улсын Үндсэн Хууль, сонгуулийн хуулиуд, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль, Олон нийтийн радио телевизийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, эрх зүйн акт, Нутгийн радиогийн дүрэм, ажилтны ёс зүйн дүрэмд нийцүүлэн баталж, мөрдөнө

12.3. Сонгуулийн үеэр сонгогчдын боловсролд зориулсан төрөл бүрийн нэвтрүүлэг, мэдээллийг тодорхой цагт, тодорхой давтамжтай хүргэнэ.

12.5 Сонгуулийн үеэр улс төрийн нам, нэр дэвшигчдийн төлбөртэй нэвтрүүлгийг дамжуулахдаа адил тэнцүү байх зарчмыг гол зарчим болгож, сонгуулийн нэвтрүүлгийн хуваарь, нэвтрүүлгийн үргэлжлэх цаг, улс төрийн нам, нэр дэвшигчдийн төлбөртэй нэвтрүүлгийн үнэ тарифыг баталж, мөрдөнө

12.6 Сонгуулийн үеэр төлбөрт нэвтрүүлэг дамжуулахдаа радиогийн жирийн өдрийн нэвтрүүлгийн цагийг хасахгүй

12.7. Нам эвсэл, нэр дэвшигчдийн сурталчилгаанд нутгийн радиогийн олны танил болсон дуу хоолой бүхий хөтлөгч, нэвтрүүлэгч, сурвалжлагч, уран бүтээлчид оролцохыг хориглоно.

12.8 Нам, эвсэл, нэр дэвшигчид нутгийн радиогоор сурталчилгаа хийхдээ түүний тогтоосон хуваариар оногдсон цагт явуулах бөгөөд сурталчилгааны материалаа өөрсдөө бэлтгэж, радиогийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүй хугацаанд нь хүлээлгэн өгнө.

12.9 Нутгийн радио сонгуулийн төлбөртэй нэвтрүүлэг, зар сурталчилгааны төлөө хариуцлага хүлээхгүй

12.10 Энэ дүрэмд тусгагдаагүй харилцааг дүрэм, радиогийн хөдөлмөрийн дотоод журамд нийцүүлэн улс төрийн нам, нэр дэвшигчидтэй хийх гэрээгээр зохицуулна

### **АРВАН ГУРАВ. ИРГЭНИЙ САНАЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ**

13.1 Иргэн нутгийн радиогийн үйл ажиллагаа, Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл, ажилтнуудын ажил, ёс зүй, мөн тухайн радиогоор өөрийн тухай гарсан ташаа мэдээллийн талаар санал гомдол гаргах эрхтэй

13.2 Менежер иргэний санал гомдлыг хүлээн авч, ажлын гурав хоногоос доошгүй хугацаанд хариу өгнө

13.4 Иргэний санал гомдол үндэслэлтэй бол нэвтрүүлгээрээ ташаа мэдээллийн залруулгыг иргэний хүссэн хэлбэрээр нэвтрүүлнэ

13.5 Радиогийн менежерт хандсанаар санал гомдол нь барагдаагүй бол иргэн Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлд хандаж болно

13.6 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл иргэний гомдлыг шалгаж, ажлын долоо хоногийн дотор шийдвэрийг хүргүүлнэ. Тухайн санал гомдлыг шалгахад илүү хугацаа шаардлагатай бол энэ тухайгаа энэ дүрэмд заасан хугацаа дуусгавар болохос өмнө иргэнд мэдээлнэ.

13.7 Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөлийг шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй нөхцөлд иргэн шүүхэд хандах эрхтэй

13.8 Иргэний өргөдөл гомдлыг шийдвэрлэхийн тулд Удирдах зөвлөл, Хяналтын зөвлөл ажлын хэсэг байгуулан дүгэлт гаргуулах эрхтэй

13.9 Иргэний гомдол маргаан барагдсан тухай мэдээллийг нутгийн радио өөрийн нэвтрүүлэг, мөн дүрэмд заасан аргаар олон нийтэд мэдээлнэ.

### **АРВАН ДӨРӨВ. НУТГИЙН РАДИОГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООХ, ТАТАН БУУЛГАХ**

14.1. Нутгийн радиогийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, радиогийн үйл ажиллагааг зогсоож татан буулгах эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Хяналтын зөвлөлийн дүгнэлттэй заавал танилцах бөгөөд уул асуудлыг дараалсан Удирдах зөвлөлийн дөрвөн хурлаар, гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэнэ. Энэхүү журмыг зөрчсөн шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

14.2. Дээрх шийдвэрийг гаргахдаа Удирдах зөвлөл тухайн сумын иргэдийн дийлэнх олны саналд тулгуурласан, Хяналтын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэсэн байна

14.3 Удирдах зөвлөл энэ шийдвэрээ ажлын тав хоногт багтаан сумын ИТХ-д танилцуулна

14.4 Нутгийн радио татан буулгах эцсийн шийдвэрийг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал гаргана

14.5 Сумын ИТХ шийдвэрийг хүлээн авсанаас хойш ажлын жар хоногт багтаан хэлэлцэнэ. Татан буулгах шийдвэрийг сумын ИТХ-ын дараалсан хоёр хурлаар, гишүүдийн зуун хувийн саналаар гаргана

14.6 Нутгийн радио татан буугдсан тохиолдолд өмч хөрөнгийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.